

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС БҮРЭЛДЭН ТОГТСОН ТҮҮХЭЭС

С.Ишдорж, дэд эрдэмтэн
Монголын АНУ судлалын төвийн
зохицуулах нарбйн бичгийн дарга

Америкийн нэгдсэн улс нь Умард Америкт оршдог орон бөгөөд түүний газар нутгийн хэмжээ 9,373 мянган ам километр юм. Тус орны нутгийн үндсэн хэсгийн зүүнээс баруун хүртэл 4,500 км, Умраас өмнөд хүртэл 2575 км. Харин нутгийн үндсэн хэсгээс Гавайн арлууд (муж улс) хүртэл 3,200 км юм. Аляска муж улс хүртэл 3,170 км зайтай. АНУ нь зүүн талаараа Атлантын далай, баруун талаараа Номхон далайгаар хүрээлэгддэг ба хойд талаараа Канад улстай, өмнөд талаараа Мексик улстай болон Мексикийн булангаар хиллэдэг.

Одоо АНУ 256 сая гаруй хүн амтай байна. Нийт хүн амын 95 гаруй хувь нь энэ орны нутагт төрсөн хүмүүс болж байгаа бөгөөд 30 орчим саяыг нөгр хүмүүс, 20 шахам саяыг Латин америк гаралтай хүмүүс, нутгийн уугуул хүмүүс болох индианчууд, эскимосчууд 1,5 сая гаруй байна.

Здүгээгээс 20 мянгаас 40 мянган жилийн тэртээ Умард Америкт Ази тивээс Камчатка, Аляскаар дамжин анхны хүмүүс очиж суурьшсан гэж америкийн түүхч-эрдэмтэд үздэг байна. Тэдгээр хүмүүс нүүдлийн ахуй амьдралтай байсан гэж бастэмдэглэжээ. Тэдгээр хүмүүсийн зарим хэсэг нь урин дулаан улирал бүхий Төв болон Өмнөд Америкт очиж суурьшсан бололтой.

Сүүлийн мөсдөлт барагцаалбал одоогоос 10 мянган шахам жилийн өмнө дуусаж Зүүн хойд Азийн Камчатка, Умард Америкийн Аляскыг Бөринговын хоолой зааглах болсон гэж олон орны эрдэмтэн мэргэд үздэг ажээ.

Олон мянган жилийн турш Европынхон Европ тив, Ази тивийн хооронд Америк оршдог, тэнд энэ нутгийн аль эртний уугуул оршин суугчид-индианчууд, эскимосчууд амьдардаг гэдгийг мэддэггүй байжээ. Манай тооллын X зуунаас эхлэн XV зууны бараг эцэс хүртэл Европ тивээс усан замыг товчлон шууд Ази тив хүрэхээр Умард Европоос хэсэг бүлгээр хүмүүс далайн аялал хийж байсан боловч Европ, Ази тивийн хооронд бүхэл бүтэн Америк тив байдгийг тэд нээж чадаагүй байна. 1492 оны 8 дугаар сарын эхээр Испанийн хаан Фердинанд, түүний хатан Изабелла зардал гаргаж дэмжлэг

үзүүлснээр Италийн далайчин Христофер Колумба Европоос далайгаар баруун тийш аялан шууд Ази тивэд хүрч болно гэж найдан аялалд 3 далбаат онгоц ("Санта Мариа" 40 хүний бүрэлдэхүүнтэй, "Пина" 25 хүний бүрэлдэхүүнтэй, "Пинта" 25 хүний бүрэлдэхүүнтэй) - оор гарчээ. Тэд хоёр сар гаруй далайгаар явсны дараа мөн оны 10 дугаар сарын 12-нд Багаамын нэг аралд хүрч ирснээ Ази тив орчмын аралд ирлээ гэж боджээ. Колумба уг арлыг Сан Сальвадор гэж нэрлэсэн байна. Энэ арлын хүмүүс нь Ази царайтай, бараг хувцасгүй шахам, өвсөн овоохой (Хижин)-д амьдарч байсан тул Колумба өөрсдийгөө яах аргагүй Ази тив, тухайлан энэхтхэгийн эргийн аралд ирэв гэж бодон. Тэндхийн хүмүүсийг индианчууд буюу уэст-индианчууд гэж нэрлэжээ. Колумба Сан Сальвадор арлаас Куба болон одоогийн Гаити, Доминиканы БН улсад очоод, дараа жилийн хавар нь Испанид буцаж иржээ. Тэд өр нь өөрсдийгөө Умард, Өмнөд Америкийн дунд хэсэгт ирснээ ч мэдээгүй байна. 1493 оны сүүлээр болон дахин хоёр удаа аялахдаа ч Колумба Карибын тэнгисийн зарим арал болон Төв, Өмнөд Америкийн эрэг хүрснээс биш, Умард Америкт огт очоогүй ажээ. Харин Колумбын дараагаар аялсан олон хүний нэг болох Италийн далайчин Америго Веспуччи 1499 онд Испанийн өмнөөс (учир нь Испани зардлыг нь гаргасан), 1501 онд Португалийн өмнөөс (зардлыг нь Португали гаргасан) тус тус аялал хийснийхээ үр дүн болгон илтгэл бичиж, түүндээ түүний очсон газар бол Азийн хэсэг гэхээсээ огт өөр "Шинэ өртөнц" байна гэж тодорхойлсон нь олон орны хүмүүсийн анхаарлыг татан, хүмүүс уг "шинэ өртөнц"-ийг түүний нэрээр "Америка" гэж нэрлэх болж, дэлхийн бөмбөрцөгийн баруун хагас нь бүхэлдээ "Америк" тив гэж хүн төрөлхтний түүхэнд нэрлэгджээ.

Ийнхүү Христофер Колумба Америк тивийг нээснээс хойш Европоос Умард Америкт ирж суурьшсан анхны цагаан арьстан хүмүүс бол голланд, англи хүмүүс мөн гэж АНУ-ын түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Харин тэр үеийн тэнгисийн хүчирхэг улс болох Испани, Португалийн хүмүүсээс Төв болон Өмнөд Америкт ирж суурьшнаас гадна Испани нь Умард Америкийн өмнөд болон баруун хэсэг, Франц нь Канадын зарим хэсэг болон Умард Америкийн төв хэсэг, Англи нь Канадын нэлээд хэсэг болон Умард Америкийн зүүн хэсгийг, Хаант Орос нь Аляскийг тус тус эзэмшиж колончлох болжээ.

1607 онд англи хүмүүс Жеймстонд, 1620 онд Плаймаутад, 1630 онд Массачу-зетсэд, 1664 онд голландчуудыг Нью-Амстрөдамвас (Нью-Йоркийг голландчууд ингэж нэрлэдэг байсан) зайлуулан Нью-Йоркт, 1692 онд Пенсильваньд, 1733 онд одоогийн Жоржиа штатад гэх мэтээр суурьшин эзэмшиж колончлох болсон байна. 1619 онд голландчууд нь Африк тивээс 20 нөгр арьстанг Виргина штатад авчран, английн колоничлогч нарт зарц (боол) болгон худвалджээ. Ерөнхийдээ Англи нь хожмын АНУ-ын Атлантын эргийн штатуудыг эзэмшин колончлож байжээ. Атлантын далайн эргийн энэхүү урт зурвас колонийн нутгийг дотор нь 3 хэсэг болгон эзэмшиж байжээ.

Үүнд: түүний умард хэсгийг "Шинэ Англи" колониуд гэж нэрлэн, тэдгээрт одоогийн Мэн, Нью-Хэмпшир, Вермонт, Массачузетс, Род-Айленд, Коннектикут штатууд хамрагдаж байжээ. "Шинэ Англи" колониудад дунд ангийн нэлээд боловсролтой шашны пуританурсгалыг баримталсан худалдаа, үйлдвэр эрхэлдэг хүмүүс ирж суурьшсан учир энд арилжаа наймаа явуулан, аж үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх бололцоотой байсан байна. Харин Англиас энд суурьшсан хүмүүс нь шашны пуритан урсгалыг баримталдаг байсан учир Английн хаанаас тусгайлан газар олгохгүй тул тэд өөрсдөө газрыг нутгийн уугуул хүмүүс - индианчуудаас худалдан авч болохыг зөвшөөрчээ.

Атлантын далайн эргийн Английн урт зурвас колони нутгийн өмнөд хэсгийг "Өмнөдийн колониуд" гэж нэрлэн, тэдгээрт одоогийн АНУ-ын Мэриленд, Виргина, баруун Виргина умард Каролина, Өмнөд Каролина, Жоржиа штатууд болон Вашингтон тойрог хамрагдаж байжээ. Эдгээр колониуд суурьшсан англи хүмүүс нь католик шашин шүтдэг байсан учир Английн хааны зөвшөөрснөөр тэдэнд аж ахуй эрхлэхэд нь Америкийн газар нутгаас тодорхой хэмжээний газар худалджээ. Мэриленд штатад суурьшсан англи хүмүүс нь түргэн баяжиж, олон ажилчинтай болсноос гадна мөнгө багатай хүмүүс нь өчүүхэн газар авч, ерөнхийдээ ядуучууд болсон байна. Виргина штатын өмнөд хэсэг болон Умард, Өмнөд Каролина штатуудын нутагт тамхины аж ахуй өргөн хөгжүүлэн, түүнээс колончилогчид ихээхэн орлого олж байжээ. Харин Жоржиа штатад цөөн англичуудаас гадна Ирланд, Шотланд, Итали, Австри хүмүүс, мөн Португалиас нэлээд тооны өврөй ирж суурьшсан учир эхний үед хөгжил нь удаан байсан боловч 1733 онд Жеймс Оглөторпе Английн хаан ПГеоргийн нэрийн өмнөөс 100 шахам англи хүмүүсийг нэмж авчирч суурьшуулан, шинэ журам мөрдүүлэхдээ боолын хөдөлмөрийг ашиглан том аж ахуй эрхлэн явуулах ажлыг хөхүүлэн дэмжсэний дараа энэхүү штатын хөгжил түргэсжээ.

Атлантын далайн эргийн Английн урт зурвас колони нутгийн "Шинэ Англи" колониуд болон "Өмнөдийн колониуд"-ын хоорондох хэсгийг "дундад колониуд" гэж нэрлэн, тэдгээрт өнөөгийн АНУ-ын Нью-Йорк, Пенсильвани, Нью-жерси, Делаваре штатууд хамрагдаж байжээ. Эдгээр штатад Европоос ирсэн анхны суурьшигчид нь тэр болгон англи хүмүүс байгаагүй юм. 1620-ээд оны эхээр голландчууд Мэнхэттан арал (одоогийн Нью-Йорк)-д ирж суурьшин, энд Нью-Амстердам нэртэй хотыг анх үүсгэн байгуулж, Гудзон голоос Оранж боомт хүртэл газрыг эзэмшиж байжээ. Түүгээр ч үл барам голландчуудын хяналт Делаваре гол хүртэл газрыг хамарч байв. Эдгээр эзэмшлээ голландчууд шинэ Нидерланд гэж нэрлэн, уул нутгийн уугуул иргэд-индианчуудтай ангийн үслэг, арьс ширний арилжаа наймаа идэвхтэй хийж байжээ. 1660-аад онд шинэ Нидерландын захирагчаар вест-индианчуудтай урьд нь байлдаж яваад өрөөсөн хөлгүй болсон хатуу ширүүн догшин ааштай Пөтер Стюйвесант төмцлөгдөн ажилласанд хүмүүс дуртай биш байжээ. Атлантын далайн эргийн ангийн урт зурвас колони нутгийн яг

гол дунд нь өөр улсын эзэмшил байх нь Английн колончилогчдын сэтгэлийг ихэд түгшээж байв. Энэ үед Европт Англи, Голландын хооронд нэгэнт дайн эхэлсэн учир 1664 онд Английн байлдааны тэнгисийн хөлөг онгоцууд Нью-Амстердамын боомтыг дайрчээ. Захирагч Петер Стюйвесант тэмцэлд оршин суугчдаа босохыг уриалсан боловч тэд түүнийг дэмжсэнгүй. Ийнхүү голландчууд аргагүй байдалд автагдан бууж өгч, Шинэ Нидерланд гэдгээ орхиход хүрсэн байна.

Английн П Чарльз хаан өөрийн дүү бөйс Йоркийг энэ колониог захирагчаар томилжээ. Бөйс Йорк Шинэ Нидерландыг хоёр хэсэг болгон хувааж, Нью-Амстердамыг өөрийнхөө нэрээр Нью-Йорк гэж нэрлэн, Делаваре голоос зүүн тийших нутагт Нью-жерси гэдэг нэр өгч, түүнийг өөр хоёр язгууртанд захируулах болсон байна. Нью-Жерсид Английн пуритан шүтлэгтэй хүмүүс, Францын протестантууд, голланд, швед, ирланд шотланд зэрэг олон үндэстний хүмүүс ирж суурьшсан учир энэ колони даян бүрийн шашны үйл ажиллагаа чөлөөтэй байжээ.

"Дундад колониуд"-ад харьяалагддаг Пенсильванийг Английн Уильям Пенн гэдэг хүн бий болгожээ. Энэ хүн бол Английн чинээлэг адмиралын хүү юм. Энэ хүн Англид байхдаа сүмд татвар төлөхөөс татгалзсан учир шийтгэгдэж шоронд орж байжээ.

Пеннийн баян нь Английн П Чарльз хаанд ихээхэн хэмжээний мөнгө зээлдүүлсэн байсан учир аавыгаа нас бармагц Пенн нь аавынхаа мөнгө зээлдүүлсний баталгаа болгон Америкт амьдрахад тодорхой хэмжээний газар олгохыг хүссэнийг П Чарльз хаан ёсоор болгожээ. Тэр уг олгосон газрыг Пенсильвани гэж нэрлэсэн нь Пеннийн ой модот нутаг гэсэн утгатай нэр ажээ. Пеннийн газар нь Делаваре голоос баруун тийш одоогийн Нью-Йорк штат, Мэриленд штатын хоорондох нутаг юм. Энэ нутагт ирж суурьшсан хүмүүс нь голдуу германчууд байснаас гадна мөн ирланд, шотланд, голланд хүмүүс байжээ. Энэ нутагт нутгийн уугуул иргэд-индианчууд болон олон үндэстний суурьшигчид байсан учир Пенн эдгээр хүмүүсийг хоорондоо эвтэй ах дүүсэг байхыг уриалан, үйл ажиллагаандаа үүнийг мөрдлөг болгожээ. Үүний ч үр дүнд энэ колони нутаг түргэн өсөж өндийн, 1685 он буюу Пеннийг захирагч болсны 3 жил гэхэд нутгийн хүн ам нь 9 мянга орчимд хүрч, түүний тариачид улаанбуудай, эрдэнэ шиш, арвай тариалах явдал эрс нэмэгдэн, худалдаачид нь бусад колонитой арилжаа наймаа өргөн хийх болжээ. 1700-аад оны эцэс гэхэд энэ колони нутгийн Филадельфи хот нь Английн колониудын дотор цар хэмжээ болон худалдааны талаар хамгийн том хот болсон байна.

"Дундад колониуд"-д харьяалагддаг Делаваре-д анх 1638 онд шведууд суурьшин, түүнийг шинэ Швед гэж нэрлэж байжээ. Гэвч 1655 онд голландчууд тэндээс шведуудыг түрж гарган, Шинэ Нидерландын хэсэг болгосон байна. Харин 1664 онд Шинэ Нидерланд Английн эзэмшил болсны дараагаар Делаваре нь бөйс Йоркт харьяалагдах болжээ. Пенсильвани нь

далайд гарцгүй байсан учир Уильям Пенн 1682 онд Делаваарегийн эрэг орчим газрыг Пенсильванид харьяалуулахыг Нью-Йоркийн бэйсээс хүссэнийг өсоор болгожээ. Гэвч Делаваарегийн оршин суугчид Пенсильванийн хэсэг байхыг хүсээгүй учир 1704 онд Делаваре тусдаа колони болжээ.

"Шинэ Англи" колониудад ирж суурьшсан английн олонхи суурьшигчид нь загас агнуур, арилжаанаймаа эрхэлснээр баян худалдаачид болж хувиран, эцэстээ энэ колонийн нутгийн нийгмийн айхавтар нөлөө бүхий хүч болсноор барахгүй энэ нутагт ихээхэн нөлөөтэй байсан шашны пуритан урсгалын хүчийг ч тэмирдуулж чаджээ. "Шинэ Англи" колони нутаг нь байгаль, цаг уурын хувьд английн суурьшигчдад газар тариалан эрхлэхэд таатай биш байв. Учир нь өвөл нь урт, хүйтэн, зун нь богинохон байжээ Англиас ирж суурьшигчдын олонх нь ядуу тариачид учир амь зогоохын тулд энэхүү хүнд ажлыг арга буюу эрхлэхэд хүрсэн байна. Юуны өмнө тэд эхний үед өөрсөддөө зориулан үр тариа, идэшний ногоо тарьж ургуулах болжээ. Гэвч тариачид цаашилбал өөрсдийнхөө хэрэгцээнээс илүү ихийг тарьж ургуулах болж, арилжаа наймааг идэвхтэй хийх болсон байна. Энэ нь "Шинэ Англи" колони нутгийн тариачид-суурьшигчдыг яваандаа газрын эзэд болгон хувиргажээ. Тэдний ихэнхи нь ажлын багаж зэвсэг, хувцас хунар, гутал, гэрийн тавилга зэргээ өөрсдөө хийдэг байжээ. Түүнчлэн энэ колони нутагт хүн ам өсөхийн дагуу хот, тосгон барьж байгуулах ажил эрчимтэй явагдах болсон байна. Үйлдвэрлэл, арилжаа наймаа өсөхийн зэрэгцээ далайн эргийн ой модоор бүрхмэл энэ нутагт тэнгисийн хөлөг онгоцны үйлдвэрүүд барьж байгуулж эхэлсэн байна. Ингэснээр "Шинэ Англи" нь худалдааны томоохон төв болж хувирчээ.

"Өмнөдийн колониуд"-ын газар зүйн байдал нь английн колончилогчдоос хөдөө аж ахуйг эрхлэн хөгжүүлэхэд таатай нутаг болсон бөгөөд энд газрын чинээлэг эзэд, ядуу тариачид, Африкаас авчирсан хар арьстан зарц нар (боолчууд) амьдарч байжээ. Энэ нутгийн үржил шимтэй хөрс урин дулаан уур амьсгал нь ялангуяа тамхи, цагаан будаа тарьж ургуулан, ихээхэн орлого олоход нөлөөлсөн байна. Тамхины болон цагаан будааны тариалангийн талбайн эзэд нь энэ колони нутгийн гол баян хүмүүс болжээ. Гэтэл английн колончилогч-суурьшигчдын ихэнх нь газаргүй ядуучууд байсан учир тэд цөөн тооны газрын эздийн зарц болон хувирчээ. Энэ колони нутагт баячуудын тамхины болон цагаан будааны тариалангийн талбайн хамаг хүнд хүчир ажлыг цагаан арьстан ядуу суурьшигчдаас гадна хар арьстан зарц нар хийж гүйцэтгэдэг байв. Энд газрын эзэн бүр хэд хэдэн зарцтай байх нь хэвийн үзэгдэл болсон бөгөөд боолчуудын хөдөлмөрийг их өргөн хэрэглэдэг байжээ. Өөрөөр хэлбэл эндхийн тамхины болон цагаан будааны тариалангийн нүсэр талбайн ажлыг боолчууд нугалж байсан байна. Өмнөдийн колони нутгийн Чарльзтаун, Өмнөд Каролина, Саваннах, Жоржиа зэрэг боомт хотууд нь Английн худалдаачид болон тамхи, цагаан будааны тариалангийн талбайн эздийн хоорондын арилжаа, наймааны гол төвүүд нь

болж хувирчээ.

"Дундад колониуд" нь далайн эргийн үржил шимтэй хөрс бүхий өргөн тал газар бөгөөд уур амьсгалын хувьд "Шинэ англи" колонийг бодвол урин дулаан, "Өмнөдийн колониуд"-тай харьцуулбал арай сэрүүн учир энэ нутагт газар тариалан, мал аж ахуйг эрхлэхэд туйлын таатай юм.

Энэ колони нутагт Европоос ирж суурьшсан анхны хүмүүс нь "Шинэ Англи"-д болон "Өмнөдийн колониуд"-ад ирж суурьшигчдын нэгэн адил тариачид байжээ. Гэхдээ тэд далайн эргийн үржил шимтэй хөрс бүхий том аж ахуйнуудад амьдран, индианчуудтай ойр дотнын харилцаатай жилилаад байжээ. Тэд улаан буудай, арвай, хөх тариа болон бусад үр тарианы арвин ургац хурааж авдаг байснаас гадна Нью-Йорк, Пенсильвани, Нью Жерси колониудад жимсний болон мал аж ахуйг өргөн хөгжүүлж байв. Зөвхөн 1760 онд Нью-Йорк колони нь 80,000 гаруй баррель⁶(бочок) улаанбуудайны гурилыг бусад колониуд экспортлон гаргаж худалдсан байна. "Дундад колониуд" цэцэглэн хөгжих тутам тэдний тариачид арилжаа наймаа өргөн хийж, мөн бусад суурьшигчид мод, модон эдлэл, үслэгийг их хэмжээгээр худалдаалах болжээ. Энэ колони нутгийн Гудзон голын адагт байдаг Нью-Йорк хот, мөн Де лаваре голын адаг орчим оршдог Филадельфи хот нь богино хугацаанд худалдааны төвүүд болон хувирчээ. "Дундад колониуд"-ын бараа таваар нь бусад колониуд болох Вест-инд, Европ руу экспортод гардаг байв. "Дундад колониуд"-ын худалдаачид арилжаа наймаанаас ихээхэн баяжиж байв. 1768 он гэхэд Филадельфи хот нь колониудын дотроос тэнгисийн хамгийн том боомт болжээ. Энэ колони нутагт бараа таваар үйлдвэрлэх ажил эрчимтэй өрнөж, эрэгтэй, эмэгтэй ажилчид бугуйн цаг, ханын цаг, цоож, буу зэвсэг, нэхмэл болон цэмбэн эдлэл, малгай, нүдний шил, цахилгаан багаж хэрэгсэл зэрэг зүйлийг үйлдвэрлэн гаргадаг байжээ. Энд Европын олон орны суурьшигчид байсан учир тэд энэ колони нутгийг хөгжүүлэхэд өөрсдийнхөө чадал бүхнийг хийж байсан байна. Тухайлбал, Шведийн суурьшигчид өөрсдийнхөө улсад байдаг дүнзэн байшинг, голландын суурьшигчид модон балконтой туйбуун байшинг, германчууд түлээ мод галладаг ширмэн зуухыг анх удаа Америкт дэлгэрүүлсэн гэж АНУ-ын түүхэнд тэмдэглэжээ. Энд олон орны янз бүрийн шашин шүтлэг бүхий хүмүүс ирж суурьшсан учир аливаа шашныг гадуурхан хэвчлэх явдлыг арилган, чөлөөтэй болгожээ. Ингэснээр ч энэ колони нутагт 1700-аад оны дундаас эхлэн янз бүрийн шашны сургууль, Коллежууд нэлээд олноор байгуулагдаж ажилласны дотор Нью-Жерсийн коллеж (одоогийн Принсептоны Их Сургууль), вангийн коллеж (одоогийн Колумбийн их сургууль) зэрэг орж байна. Энд "Өмнөдийн колониуд"-ыг бодвол бослууд цөөн байжээ. Гэхдээ боолын системийг устгаж, боолчуудыг эрх чөлөөтэй иргэд болгох хөдөлгөөн "Дундад колониуд"-д эхлэн өрнөж, энэ нь бусад колониуд ч түгэн дэлгэрч, Америкийн Нэгдсэн Улсын тусгаар тогтнолыг зарласан хувьсгалт дайны үед биеллээ олсон байна.

⁶Баррель (бочок) -д 142 литр шийтэн буюу хуурай зүйл багтдаг

Одоогийн АНУ-ын нутагт Английн эзэмшиж байсан колончуудад уул нутгийн уугуул ард түмэн болох индианчуудын Ирокуисын холбоо*, Вампаноаг, Пекьюот, Делаваре, Поухатан, Тускарора, Чероки, Чиккасау, Крикийн холбоо, Чоктау зэрэг овог аймгууд оршин амьдарч байжээ.

Эхний үед Английн эзэмшсэн колончуудын индианчууд нь английн суурьшигчидтай нөхөрсөг харилцдаг, шинэ газар амьдрахад тэдэнд тус дэм үзүүлдэг байжээ. Гэвч английн суурьшигчид колони нутагт байгаа индианчуудад Христосын буюу Европын шашин, зан заншил, үзэл санааг тулган хүлээлгэхийг хичээн, ялангуяа колончуудын зах хязгаарын англи суурьшигчид Аппалачийн нуруунаас баруун тийших тэдний газар нутгийг түрж авах зэрэг оролдлого байнга хийх болсон нь индианчуудын дургүйг хүргэж, тэдэнтэй зөрчилдөх байдалд оруулсан байна. 1630-аад оны үед "Шинэ Англи" колонийн суурьшигчид, индианчуудын хооронд хэд хэдэн удаа мөргөлдөөн болжээ. 1637 онд Шашны Пуритан урсгалын бүлгийнхэн Пекьюот тосгоныг дайрч довтолж бүх гарцыг нь хаагаад, колончлогчид тосгоныг газрын хөрстэй

тэгшлэн, түүний хэдэн зуун эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүдийг галдан шатаажээ. 1675 онд "Шинэ Англи" колони нутгийн индианчуудын бүлгүүд хоорондоо нэгдэж, Вампаноаг овгийнхны тэргүүн Метакометаар (колониудын оршин суугчдад энэ хүн ван Филип гэж алдаршсан) удирдуул английн колончлогчид руу довтолж, Массачузетсийн булан дахь колони, Нью-Хэмпшир, Мэн дэх тэдний 25 орчим суурьчуудыг устгажээ. Иймэрхүү цус урсгасан, эвдэлж сүйтгэсэн ширүүн тэмцэл олон жилийн турш үргэлжилсэн байна.

Английн суурьшигчид өөрсдийн эзэгнэж байсан колонийн нутгаас халин, Аппалачийн нуруунаас баруун тийш, мөн өмнө зүг Флоридын хойгийн нутаг руу өнгөлзөх болсон нь тур үеийн өөр хоёр колончлогч гүрэн - Франц, Испантай Английг мөргөлдөхөд хүргэжээ.

Англичуудыг Умард Атлантын далайн эргийн нутагт ирж суурьшин колони болгон хувиргаж байх үед францчууд Канадын зүүн өмнөд хэсгээс эхлэн 5 нуур орчим нутаг болон Аппалачийн нуруунаас баруун тийших Огайо голын хөндийг уруудан Мексикийн булан хүртэлх өргөн уудам нутаг, мөн одоогийн АНУ-ын газар нутгийн төв хэсгийг эзэмшин, түүнийг "Шинэ Франц" гэж нэрлэж байжээ. Францын суурьшигчид нутгийн уугуул хүмүүс индианчуудтай нөхөрсөг харилцан, тэдэнтэй арилжаа наймааг чөлөөтэй хийдэг байжээ. Хэрэв Английн суурьшигчид индианчуудыг газар нутгаас нь түрж, тэдний дургүйг хүргэдэг байсан бол харин францын суурьшигчид тэдэнтэй арилжаа наймаа хийхдээ тэгдэггүй, тэднийг газар нутгаас нь түрэх оролдлого хийддэггүй байсан явдал индианчуудад ихэд таалагдадаг байжээ. Тийм ч учраас индианчуудын зарим овог тухайлан гурончууд болон Алконкуин овгийнхон францчуудын холбоотон болсон байна. Түүгээр ч үл барам индианчууд Умард Америк тивийг сайтар нээх гэсэн францчуудын

*Энэ холбоонд Мохавк, Сенека, Онеондага, Онейда, Каюга зэрэг омгууд багтаж байжээ.

судалгаа-шинжилгээний ажилд үлэмж тус дэм үзүүлж байсан байна. Тодруулж хэлбэл Францын язгууртан Роберт Де Салле 1681 оны 12 дугаар сард 23 франц, 31 индиан хүмүүсийн хамт Эрие, Гурон, Мичиган нууруудыг гатлан, Иллинойс гол, Миссиссипи мөрнийг уруудан аялсаар дараа жилийн 4 дүгээр сарын 1-нд Мексикийн ууланд хүрсэн нь францчуудаас Огайо болон Миссиссипийн хөндийнүүдийг нээн эзэмшихэд үлэмж тус болсон байна.

Ийнхүү Ла Салле 5 их нуураас Миссиссипийн хөндийг дайруулан Мексикийн булан хүртэлх үлэмжийн их газрыг Францын эзэмшил болгон зарлаж, түүнийг өөрийн улсын ялгуусан хаан Луисын нэрээр Луизиана гэж нэрлэх болжээ. Ингэснээр "Шинэ Франц" нь Умард Америк дахь Английн колониудтай шууд хиллэх болсон байна. Хэрэв 1600-гаад оны турш "Шинэ Франц"-ын томоохон хэмжээний хот нь Сант-Лауренс голын эрэг дэх Квебек хот, мөн индианчуудтай үслэгийн худалдааны цэг Монреал байсан бол 1718 онд Миссиссипи мөрний адагт Нью Орлеаныг "Шинэ Франц"-ын чухал боомт болгон барьж байгуулжээ. Гэвч Луизианы хөгжил удаан байсан бөгөөд 1745 он гэхэд Миссиссипи мөрний адаг болон Мексикийн булан орчмын нутаг нийтдээ 3200 Европ суурьшигчид, 2000 негр оршин амьдарч байснаас энэ байдла тодорхой харагдаж байна.

Ер нь 1600-гаад оны туршид болон 1700-аад оны эхээр Францын гол зорилт нь Английн суурьшигчдыг Аппалачийн нуруунаас баруун тийш халин гарахыг барих, Англитай хийж байсан үнэт үслэгийн худалдаандаа хохирол учруулахгүйг чармайж байв. Энэ зорилтоо биелүүлэхийн тулд тэд английн суурьшигчдийн эсрэг индианчуудын тэмцлийг элдэв хэлбэрээр дэмжихийн зэрэгцээ индианчуудад буу зэвсэг болон бусад зүйлийн тусалцаа үзүүлж байв. Өөрөөр хэлбэл индианчуудын болон өөрсдийнхөө эзэмшсэн газрыг хамгаалах үүднээс францчууд Нью-Орлеанаас Миссиссипи мөрний дагуу Канад хүртэл хамгаалалт бэхлэлтүүдийг хийж байв. Үүнээс үзэхэд Англи, Францын хооронд Америк дахь газар нутгийн эзэмшлийн төлөө дайтах мөч улам бүр ойртож байв.

Энэ үед Америк дахь Английн колониудын өмнөд талаар хиллэж байсан Испанийн колони эзэмшигчидтэй Англи өрсөлдөж, сөргөлдөх явдал бэс ихсэж байна. Христопфер Колумба Вест-Индид хүрснээс хойших 50 гаруй жилд тэр үеийн тэнгисийн хамгийн хүчирхэг гүрэн - Испани нь Америк тивийн ихээхэн хэмжээний газар нутгийг эзлэн колоничлохдоо Төв Америкт болон Умард Америкийн баруун өмнөд хэсэгт ноёлж байсан индианчуудын Азтекийн овгиинхны том эзэнт улсыг дайтан нураан, индианчуудыг хүйс тэмтэрч, Америк тивд өөрийн эзэнт улс байгуулснаа "Шинэ Испани" гэж нэрлэжээ. Энэхүү "Шинэ Испани"-д Бразилиас (үүнийг Португаль эзэмшиж байсан) бусад Өмнөд Америкийн бүх орон, Төв Америк бүхлээрээ, Вест-Индийн арлууд багтаж байжээ. Түүгээр ч барахгүй "Шинэ Испани" хэмээх Испанийн эзэнт улс газар нутгаа Умард Америк руу улам тэлэн, одоогийн АНУ-ын

баруун өмнөд болон баруун хэсэг, Флорида хойгийг Мексикийн булангийн эрэгтэй нь эзэгнэж байжээ. "Шинэ Испани" хэмээх эзэнт улсыг Испанийн хаан өөртөө харьяалуулж байжээ.

"Шинэ Испани" Умард Америк руу газар нутгаа тэлж өргөжүүлэн, Английн колониудтай хиллэх болсон нь Английн колонилогчдыг ихэд сандаргаж байв. Тэгээд ч Испаниудыг Флоридаас умард зүг рүү ахиулахгүй байж байхын тулд англичууд Жоржиа колони (одоогийн АНУ-ын Жоржиа штат)-ийг бий болгожээ. Англичуудыг Жоржиад суурьшсан испаниуд маш их хилэгнэн дургүйцжээ. Энэ нь 1739 онд Умард Америкт Испани, английн колонилогчдыг дайтахад хүргэсэн байна. Жоржиа колонийн захирал Жеймс Оглеторп энэ нутгийн "Индианы Крикийн холбоо болон Черокийн овгийнхонтой нөхөрсөг холбоотой болсны үр дүнд индианчуудын бүлгүүд, английн колонилогчид хамтран испаниудын эсрэг тэмцжээ. Уг тэмцэл хэдэн жилийн турш үргэлжлэн 1748 онд Ликс-Ла-Чареллед хоёр тал гэрээ байгуулж гарын үсэг зуржээ. Энэ тэмцлийн үр дүнд Английн колонилогчид давуу байдалтай нь харагдсан боловч гойд хожоо тэдэнд төдий л гараагүй байна.

Умард Америкт колони эзэмшлийн давуу байдал олж авахын тулд англи, францын колонилогчдын хоорондын зөрчил улам хурцалсаар байлаа. 1600-гаад оны сүүлээс эхлэн 1700-гаад оны дунд хүртэл хугацаанд (тухайлбал 1689 оноос 1743 оны хооронд) Америкт энэ хоёр орон хоорондоо 3 удаа дайтжээ. Умард Америкт эдгээр дайн аль аль талдаа үр дүн багатай төгсөж байв. Францчууд, тэдний холбоотон-индианчуудаас английн суурьшигчид руу довтолоход нь англичууд "Шинэ Франц"-ын гол суурьшил-Квебек, Луисбург руу харшу дайрч байжээ. Дайтах бүрийн эцэст энх амгалан тогтоох гэж амаргүй хэлэлцээ хийдэг байв. Ингэлээ гээд Умард Америкт энэ хоёр гүрний колонийн эзэмшилд онц гойд өөрчлөлт гардаггүй байжээ. Жаахан дорвитой өөрчлөлт гэвэл Франц нь Акида (одоогийн Нова Скотиа) болон Ньюфаунлэндийг Английн эзэмшилд байхыг зөвшөөрсөн явдал юм.

Ингэснээр энх тайван байдал энэ хоёр колони гүрний хооронд төдийлэн удаан үргэлжилсэнгүй. Францын колонилогчид нь Огайо голын хөндийг Роберт де Ла Салде нээснийг баримтлан Миссиссипи мөрний адагт суурьшсан францчуудыг "Шинэ Франц"-ын бусад хэсэгтэй холбодог гол чухал газар хэмээн үзэж, энэ хавийн үржил шимтэй хөрс бүхий нутгийг өөртөө ямагт байлгахыг эрмэлзэж байв. Гэтэл Английн колонилогчид нь Аппалачийн нуруунаас баруун тийших уул газар болон Огайо голын хөндийг өөртөө авч, тэнд суурьших, үслэгийн арилжаа наймааг Францын колонилогч-худалдаачидтай биш, хөрин индианчуудтай шууд хийж байх зэрэг шаардлага тавьж байжээ. Энэ зорилгоор 1747 онд Английн 2 дугаар Георг хаан колонилогчдадоо зориулан Огайогийн компани гэдгийг байгуулан, түүнд 200,000 акр (81,000 гектар) газар олгохоор болж, Огайогийн хөндийг

* 1707 онд Англи, Уэльс, Шотланд нэгдэж нэг вант улс болсныг Их Британи гэж нэрлэжээ.

суурьшин эзэмших зарлиг буулгажээ. "Шинэ Франц"-ын захирагч үүнийг дуулж мэдмэгцээ Огайогийн хөндийн дагуу олон бэхлэлт цайз, түүний дотор Дунайе цайзыг барьж байгуулах ажлыг түргэвчилсэн байна.

1753 онд англичууд Огайогийн хөндийн дагуу барьж байгуулж байгаа бэхлэлт цайзуудаа даруй зогсоохыг францчуудаас шаардсан үүрэг даалгавартайгаар залуу Жорж Вашингтоныг явуулжээ. Францчууд энэ шаардлагыг үл хайхран, бэхлэлт цайз барих ажлаа үргэлжлүүлсээр байв. 1754 онд Виргинын цагдаагийн жижиг бүлгийг толгойлон, Дунае цайзыг эзлэн авах даалгавартайгаар Жорж Вашингтон Огайод буцаж очжээ. Гэтэл хүний тоогоор эрс давамгайлж байсан францчууд Жорж Вашингтон болон түүний цэргийг Дунае цайзаас түрэн зайлуулж, улдан хөөх үед Виргинчууд маш түргэн өндөр хаалт бэхлэлт босгон Вашингтоны цэргийг аварсан байна. Францчууд уг бэхлэлтийг бүсэлж, виргинчүүдийг хүчээр буулгаж авчээ. Харин Жорж Вашингтон, түүний цэргүүд Виргина дэхь өөрсдийнхөө гэр оронд харьцгаасан байна. Огайогийн хээр талд францчууд ийнхүү уугуул нутгийн хүмүүстэй мөргөлдөж цус урсгасан нь францчууд, индианчуудын хооронд дайтахад хүргэжээ. Энэ дайн богино хугацаанд болж өнгөрсөнгүй, харин нэлээд үргэлжилж сунжирсан байна. Францчуудын колоничлогчид, индианчуудын хооронд зэвсэгт тэмцэл явагдаж байсан нь яг энэ үед Европт эхэлсэн 7 жилийн дайнд Англи, Франц хоёр эсрэг тэсрэг тал болон оролцжээ. Энэ байдал ч Умард Америкт англи, францын колоничлогчидыг хоорондоо дайтахын бас нэг шалтгаан болжээ.

Умард Америкт англи, францын колоничлогчидын хооронд явагдсан энэ дайны эхний үед францчууд удаа дараа ялалт байгуулж байв. Үүний шалтгаан нь францчуудын эзэмшсэн колониуд нэгдсэн нэг удирдлагатай, мөн мэргэжлийн арми, тэнгисийн байлдааны хөлөг онгоцуудтай байснаас гадна хэдийгээр францын колоничлогчид өрөнхийдөө индианчуудтай дайтаж байсан ч гэсэн тэднээс өөрсөддөө үнэнч байсан Гурон, Алконкуинз овгийнхныг талдаа оруулж чадсантай бас холбоотой юм. 1755 онд Английн генерал Эдуард Брэддокоор командлуулсан цэргүүд колони нутгийнхны зөвлөмжийг үл хайхран, Дунае цайзыг шууд дайран эзлэхээр Огайогийн хээр газраар цуваа болон явж байхад нь тэднийг францчууд гэнэт довтолжээ. Энэ тулалдаанд генерал Брэддок алагдаж, англичууд хүнд ялагдал үзжээ. Харин Брэддокийг дагалдаж явсан Жорж Вашингтон командлагыг гартаа авч, үлдсэн цэргүүдтэйгээ ухарснаар Огайогийн хөндий францчуудын мэдэлд бүрэн орсон байна. Энэ мэтчилэн англичуудын эсрэг францчууд хэд хэдэн удаа ялалт байгуулжээ.

Гэвч хоёр жилийн дараа буюу 1757 онд байдал эрс өөр болж, дайны явцад үндсэн эргэлт гарсан байна. 1757 онд Британийн өрөнхий сайдаар эрс шийдэмгий, эрэлхэг зоригтой Уильям Питт томилогдсон нь энэ дайныг ялалтаар төгсгөхийн тулд ихээхэн хөрөнгө мөнгө гарган цэрэг зэвсгийн

хүчийг нэмэгдүүлснээс гадна Умард Америк дахь колониудад хүчээ улам шургуу дайчлах, аль болох олон тооны цэрэг гаргахыг тулгажээ. Үүний зэрэгцээ Умард Америк дахь английн колониуд нь францынхыг бодвол хүн ам олонтой бат бэх суурьшсан байснаас гадна тэд өөрсдийнхөө талд индианчуудын дайтахад хамгийн гарамгай Ирокуоис овгийнхны холбоог оруулж авсан байжээ. Ийм дорвитой арга хэмжээг ялалтай авсны үр дүнд англичууд удаа дараа ялалт байгуулж эхлэв. 1758 онд францын колонийн стратегийн боомт Луисбургийг буулган авч, мөн Огайогийг хөндий дахь францын эзэмшлийн хэд хэдэн цайз, бэхлэлт, түүний дотор Дунаке цайзыг эзэлжээ. Энэ цайзыг Британийн тэр үеийн ерөнхий сайд байсан Уильям Питтийн нэрээр Питтсбург гэж нэрлэсэн нь одоогийн АНУ-ын Питтсбург хот юм.

Үүний дараа Умард Америк дахь Францын колониудыг холбон хангадаг байсан төв, Сант Лауренс голын адагт байдаг, олон бат бэхлэлт бүхий, их буунууд зоосон Квебек хотыг дайтаж авсан нь дайны хувь заяаг шийдвэрлэсэн эргэлтийн үе болов.

1759 онд Английн генерал Жеймс Вольф цэргүүдтэй Сант Лауренс голыг өгсөн Монреал руу урагшилж явтал генерал Луис Монткальмаар командлуулсан францын цэргүүд дайран довтолж, ширүүн тулалдаан явагдав. Энэ тулалдаанд хоёр талын цэргийн командлагч-Вольф, Монткальм хоёулаа амь эрсэдсэн боловч англичууд ялжээ.

Ийнхүү Квебекийн дараагаар англичууд Монреалийг эзэлж авснаар, мөн зэвсэгт тэмцэл явагдаж байсан бусад зарим газарт англичууд дараа дараалан ялалт байгуулснаар Умард Америк дахь англи, францын колоничлогчидын хоорондын дайн бүхэлдээ францчуудын ялагдал, англичуудын ялалтаар дууссан байна. Англичууд Умард Америк дахь францын колонийн ихээхэн нутгийг хяналтдаа авав.

1763 онд Парис хотноо байгуулсан гэрээгээр Английн мэдэлд Миссиссипи мөрнөөс зүүн тийших үлэмжийн их газар (харин үүнд Нью Орлеан ороогүй), Канад дахь францын колони ихээхэн нутаг, таван нуурын сав газар очжээ. Франц нь Миссиссипи мөрнөөс баруун тийших эзэмшлээ өөртөө үлдээхийн тулд Нью Орлеаныг Испанийн мэдэлд шилжүүлжээ. Өөрөөр хэлбэл франц нь Умард Америкийн төв хэсэг дэх Луизиана, Ньюфаундлендын ойролцоох хоёр жижиг арал болон Карибын тэнгис дэх хэдэн арлын эзэмшилтэйгээ үлджээ.

Энэ бүхний үр дүнд Умард Америкт Атлантын далайн эргийн 13 колониор үл барам Миссиссипи мөрнөөс зүүн тийш Аппалачийн нуруу хүртэлх Огайогийн уудам хөндий, 5 нуурын сав газар зэрэг ихээхэн хэмжээний

колониуг Англи эзэмших болсон нь эдгээр колони нутаг ялангуяа 13 колони Английн колонилогчдыг дураар дургихад хүргэж байв. Хэдийгээр английн колониудад английн суурьшигчдаас гадна өөр олон орны суурьшигчид, хар арьстан нөгрүүд болон нутгийн уугуул ард түмэн-индианчуудын янз бүрийн овгууд оршин амьдардаг байсан боловч англи хэл эдгээр бүх хүмүүсийн хоорондоо харилцан нэвтрэлцэх гол хэл болж, Английн хууль дүрмийг тэд мөрддөг байжээ. Хүний эрхийн английн хууль ч Умард Америкт ирсэн нь мэдээж. Гэтэл англичууд маань Умард Америк дахь колонийн хүмүүсээс илүү эрх дарх эдэлдэг байжээ. Колониудын захирагчид яг л Британийн засгийн газар шиг ажилладаг байсан нь олон түмний дургүйцлийг хүргэдэг байв. Үүнээс үүдэн колониудын захирагчид, тэдгээрийн оршин суугчдын хооронд элдэв маргаан, зөрчил цөөнгүй гардаг байжээ. Тухайлбал 1670"-аад онд Виргина колонийн зах хязгаарын тариачид орон нутгийн хуралд тэдний цөөн хүнээр төлөөлүүлсэн болон албан татварыг нэмснийг эсэргүүцсэн хөдөлгөөн өрнүүлжээ. 1676 онд тэд колонийн төв Жамстонд ирж, захирагч Беркөлөйг зайлуулан, хотыг шатаасан байна. Гэтэл английн цэргүүд тэдгээр үймэгчдийг зэвсгийн хүчээр дарж, 23 үймэгчдийг дүүжилж хороон, захирагч Беркөлөйг албан тушаалд нь эргүүлэн тавьжээ.

Англи нь Америк дахь колониуддаа ч эдийн засгийн хувьд үнэн хэрэгтээ юуны өмнө өөрийнхөө эрх ашгийг харгалзах, дараань тэднийг бодох хэрэгтэй гэсэн бодлого явуулж байжээ. Америк дахь колониудтай хийдэг байсан худалдаанаас Англи ихээхэн ашиг хонжоо олж байжээ. Үүнийг бататган бэхжүүлэх зорилгоор английн парламент Америк дахь колониудынхаа худалдаа, үйлдвэрлэлийг хязгаарласан тогтоолшийдвэр гаргаж байв. Өөрөөр хэлбэл меркантилизмын бодлого баримталж байжээ. Америк дахь колониуд Английг өөртөө тарьж ургуулдаггүй тамхи, цагаан будаа, хөвөн зэргээр, мөн үр тариа, ой мод, төмрөөр хангадаг байснаас гадна хариуд нь Англиас хувцас, малгай, сав суулга, элдэв багаж хэрэгсэл авдаг байв. Иймэрхүү мануфактурын үйлдвэрлэлийн зүйл нь Англид олон хүний ажилтай болгож, түүний бизнесүүд, худалдаачид үүнээс ихээхэн ашиг орлого олж, баяжиж байжээ. Английн тэнгисийн хөлөг онгоцны үйлдвэрийнхэн болон тэдний эзэд ч үүнээс бас их баяжиж байсан байна.

Колониудтайгаа хийх худалдааг хамгаалж дөрхлөхын тулд английн парламент 1660-аад онд далайн тээврийн хуулиуд баталж гаргасан нь 3 чухал зүйлийг зохицуулжээ. Үүнд:

Нэгд,

колониуд сахар, тамхи зэрэг зарим барааг зөвхөн Англид буюу өөр хоорондоо худалдаж байх тухай заалт оруулсан нь тэднийг гадаадын бусад улс оронтой эдгээр барааны худалдаа хийхийг хязгаарлаж хориглосон зүйл байв.

Хоёрт,

бусад улс орноос колониудад ирүүлэх аливаа бараа тавяарыг эхлээд заавал

Англид ирүүлж байх заалт өгчээ. Энэ заалтаар бол жишээ нь: Хятадаас Нью-Йоркт ирүүлэх цай бүхий ачааг эхлээд Лондонд хүргүүлж, тэнд цайны хураамжийг авсны дараа Нью-Йорк руу ачуулах ёстой аж.

Гуравт,

колониудаас ирүүлэх буюу колониудад хүргүүлэх ёстой бүх бараа таваарыг Англид үйлдвэрлэсэн тэнгисийн хөлөг онгоцоор тээвэрлэж байх, тэгэхдээ эдгээр бүх хөлөг онгоцны дөрөвний гурван хувь нь Английнх байх ёстой ажээ.

Үүний зэрэгцээ Англи нь колониудад мануфактурын үйлдвэрлэлийг хязгаарласан хуулийг ч бас гаргаж байв.

Ер нь англичууд Америк дахь колониудаа өөрсдийнхөө дураар захирч байсан нь колони нутгийн хүмүүсийн эрх, эрх чөлөөнд шууд заналхийлсэн үйл ажиллагаа болжээ. Энэ Британийн колонийн албаны хүмүүс, колониудын оршин суугчдын хооронд үл зөвшилдөх, маргаан, зөрчил тэмцэл байнга гаргахад хүргэж байв.

Францын колоничлогчидоос Огайогийн хөндийг 1763 оны Парисын гэрээгээр авсны дараагаар Америк дахь английн колониудын нэлээд олон суурьшигчид Аппалачийн нуруунаас баруун тийших газар руу нүүж индианчуудыг түрэн, тэдний газар нутгийг булааж авах болсон байна. Энэ нь индианчуудын дургүйцлийн ихэд хүргэж, тэдний эсэргүүцэлтэй тулгарчээ. Энэ дашрамд нэг зүйлийг дурдахад мөн энэ газраас болж урьд нь францын колоничлогчид, индианчуудын хооронд дайн явагдсан билээ. Гэтэл одоо тэдэнд Британийн колоничлогчидтой тэмцэх явдал ээлжит зорилт болов. 1763 оны хавар Оттавын индианчуудын онц эрхт толгойлогч Понтиакаар удирдуулсан Жауни, Делеваре, Чиплева, Оттав болон бусад овгийнхон Огайогийн хөндийд нүүж ирсэн английн суурьшигчдийг довтолон дайрч устган, тэдний гэр орон, байшинг шатааж, английн олон цайзыг эзлэн авчээ. Гэвч англичууд нэмэгдэл хүч илгээн, Понтиакныхныг бут цохижээ. Энэ явдал нь Аппалачийн нуруунаас баруун тийших индианчуудын газар нутгийг английн суурьшигчид хамаагүй эзэгнэж болохгүй юм гэдгийг Британийн засгийн газар ойлгосны үндсэн дээр 1763 оны эцсээр английн хаан Ш Георг албан ёсны мэдэгдэл гаргаж, түүндээ Аппалачийн нуруунаас Миссиссипи мөрөн хүртэлх нутгийг засгийн газрын мэдэлд авч, харин тэнд английн колонийн хүмүүс суурьшихыг хоригложээ. Түүгээрч үлбарам Англи нь Америк дахь колониуддаа 10 мянга шахам цэрэг нэмж илгээн байрлуулахаа уг мэдэгдэлд бас дурджээ.

Энэ мэдэгдлийн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ болгон Британийн тэр үеийн ерөнхий сайд Жорж Грэнвилль Америк дахь английн колониуд тэнд байрласан английн цэргийн зардлын тэн хагасыг даах болон францтай хийсэн дайны өрийг нөхүүлэх, засгийн газрын төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1764-1765 онд хэд хэдэн тогтоолшийдвэрийг английн парламентаар гаргуулж

амжжээ. Юуны өмнө английн колониудад импортоор орж ирж байгаа элсэн чихэр, кофе болон зарим бусад зүйлээс хураах албан татварын тухай хууль, мөн Америк дахь английн колониуд өөрсдийн цаасан мөнгөн тэмдэгт гарган гүйлгээнд оруулсныг хориглосон хуулийг 1764 онд гаргуулсан нь колониудын оршин суугчид, худалдаачид, бизнес эрхэлдэг хүмүүсийн дургүйцлийг хүргэж эсэргүүцэлтэй тулгарсан байна. Ялангуяа 1765 онд тэмдэгтийн хураамжийн хууль нийтлэн, сонин хэвлэл, зарлал, мэдээлэл гаргах, календарь, тоглоомын хөзөр хэвлүүлэх зэрэгт зөвшөөрөл өгөхийн хураамж болгон төлбөр болсон нь олон түмний дургүйцлийг бүр их хүргэжээ. 1767 онд английн парламент бас "ТАУНШЭНД" нэртэй хууль гаргаж хууль бусаар орж ирсэн бараа таваарыг илрүүлэхийн тулд хүмүүсийн орон гэр, албан газрын байр зэрэгт нэгжлэн хийх эрхийг английн колонилогчид олгон, хураамж төлөлгүйгээр импортоор оруулж ирсэн бараа таваарт, нэмэгдүүлсэн хураамж ноогдуулах, эдгээрийн орлогоос Америк дахь английн албаны хүмүүсийн цалинг төлж байх зэрэг заалт оруулсан байжээ. Энэ хуульд Нью-Йорк колониин хурлыг тарааж хориглох заалт ч бас орсон байв.

Английн парламентийн энэхүү "Тауншэнд" хууль нь Америк дахь түүний колониудын оршин суугчдын уур хилэнг бадрааж, тэдний ноцтой эсэргүүцлийн шинэ давалгааг бий болгов. Британийн эсрэг олон түмний дургүйцэл Массачузетс колони, ялангуяа Бостонд маш хүчтэй өрнөжээ. Самуэл Адамсаар толгойлуулсан Массачузетс колониин хурал тэмдэгтийн хуулийг эсэргүүцсэний нэгэн адил энэхүү "Тауншэнд" хуулийг эсэргүүцэхийг бусад бүх колониин оршин суугчдад уриалж бичиг захидал явуулснаас гадна Британиас Америк дахь колониудад бараа таваар оруулахгүй байхыг уриалжээ. Британийн засгийн газар Бостонд дэглэм журам сахиулах нэрийдлээр английн цэргийг нэмж ирүүлсэн нь тэндхийн байдлыг улам дордуулж, эдрээтэй болгосон байна. 1770 оны 3 дугаар сарын нэгэн шөнө цас орж байх үеэр нутгийн оршин суугчдын хэсэг залуучууд английн цэргийн харуулын байр луу цас мөс нүүлгэн шидсэний харцууд английн цэрэг тэдэн лүү гал нээж, хэд хэдэн хүнийг буудаж авсны дотор хар арьстан усан цэрэг Криспус Аттукс, мөн тэдний нэг ахлагч оржээ. Энэ хэрэг явдлыг АНУ-ын түүхэнд Бостон дахь хядлага гэж нэрлэсэн байдаг. Үүнийг мэдмэгцээ Бостон хотын оршин суугчид маш их дургүйцэж, английн цэргийг үзэн ядах явдал газар сайгүй болсны дүнд Английн цэргүүд Бостоны боомтонд шилжин байрлажээ. Олон түмний хүчтэй эсэргүүцлийн английн засгийн газар арга буюу харгалзан үзэхэд хүрч, мөн оны 4 дүгээр сард английн парламент "Тауншэнд" хуулиа хүчин төгөлдөр бус гэж зарласан боловч харин импортоор орж ирэх цайнаас авах татвар үнэндээ хэвээр үлдсэн байв. 1773 онд Английн парламент Америк дахь колониудад импортоор орж ирэх цайнд татвар ноогдуулж байх тухай хууль гаргав. Энэ хуулинд Америк дахь английн колониудад дэлхийн бусад орноос цайг шууд эчаалж явуулах буюу эсхүл Америк дахь колониудаас цай экспортоор гаргахдаа зөвхөн Английн Ист-Инд компанид хүргүүлж, тэр нь цаашдаа Умард Америк дахь колониудад хүргэж байхвар заажээ. Үүнд колониин жирийн оршин суугчид байтугай худалдаа наймааны хүмүүс ч дургүйцэв.

Ингээд колонийнхон Британийн ИСТ-Инд компанид цайгаа худалдахаас колониудыг татгалзахыг шаардаж, түүний цайг савлаж ачаалахаас татгалзаж байжээ. Иймэрхүү явдал Чарльстонд болсноос гадна Нью-Йорк, Филадельфиин боомтуудад цай ачаалахаар ирсэн тэнгисийн хөлөг онгоцуудыг хөөн явуулж байв. Бостон хотод колонийн оршин суугч хэсэг хүмүүс Английн ИСТ-Инд компанийн ажилчдын өмсдөг хувцас өмс өн шөнийн цагаар 342 авдар цайг далайн усанд хаяж живүүлжээ. Бостоны цайн компанийн хувьд болсон энэ хэрэг явдлыг колониудын оршин суугчид мэдмэгцээ баяр хүргэн дэмжсэнээс гадна колониудын эрх барих байгууллага-хурлуудын зөвшөөрөлгүйгээр гаргасан гадаадын гүрний парламентийн хууль дүрэм хүчин төгөлдөр биш гэдгийг эрс тэс шийдвэртэй илэрхийлэн, эсэргүүцлийн тэмцэл өрнүүлсэн байна.

Гэвч Британийн засгийн газар үймээн самуун дэгдээж байсан Массачузетсынхныг шийтгэхээр шийдэж, английн парламент улам ч хатуу хууль нэмж гаргасан нь АНУ-ын түүхэнд "Тэвчишгүй хуулиуд" гэж нэрлэгджээ. Үүнд: нэгдэх хуулинд далайд живүүлсэн олон авдар цайны үнийг төлж барагдуулах хүртэл Бостон боомтыг хаах, хоёр дахь хуулинд Массачузетсад орон нутгийн хууль эрх мэдлийг эрс хязгаарлаж, харин тэнд суудаг Британийн хааны төлөөний хүний зохих эрх мэдлийг ихээхэн нэмэгдүүлсэн; гурав дахь хуулинд Массачузетс колонийн оршин суугчид английн цэргүүдийг орон байр, хоол ундаар хангаж байхыг уриалсан, дөрөв дэх хуулинд уг үймээн самууныг таслан зогсоож чадаагүй английн албаны зарим хүмүүсийг шийтгэх тухай заалтууд оруулсан байжээ. Эдгээр хуулиа хэрэгжүүлэхийн баталгаа болгон Английн Ш Георг хаан Бостонд английн олон тооны цэрэг илгээж, түүний командлагч бөгөөд Массачузетс колонийн захирагчаар генерал Томас Гейжийг томилжээ.

Үүний хариуд Массачузетсынхан "Тэвчишгүй хуулиудыг" улам хүчтэй эсэргүүцэн, Самуэл Адамсын саналчагаар "Бичиг захидал ил хороонууд" байгуулж, тэдгээрийг бусад колонийнхэн орончдод бичиг захидлаар мэдээлэл илгээн, Америк дахь Английн бүх колонийн оршин суугчдад "Тэвчишгүй хууль"-уудыг эрс шийдвэртэй эсэргүүцэж, хүчингүй болгуулах тэмцэл өрнүүлэхийг уриалсан зэрэгцээ энэ бүх байдлыг авч хэлэлцэхээр эх газрын бүх колонийн оршин суугчдын төлөөлөгчийн их хурал хийх санал дэвшүүлжээ. Энэ саналыг Жоржиа колонийн хурлаас бусад бүх колонийн хурал зөвшөөрч, 1774 оны 9-р сард Филадельфи хотноо Эх газрын колониудын оршин суугчдын төлөөлөгчийн анхдагчаар их хурал болжээ.

Их хурлын төлөөлөгчид Британийн засгийн газрыг бодлогоо өөрчлөхийг шаардаад, колониудын хурлууд л өөрсдийнхөө бүх хуулийг гаргах эрхтэй гэдгийг сануулан, энэ эрхэд харшилсан "Тэвчишгүй хуулиуд"-ыг хүчингүй болгох, хэрэв нэг жилийн дотор үүнийг хийхгүй бол бүх колониуд англид болон ИСТ-Инд компанид экспортоор гаргах бүх зүйлийг зогсоох, мөн Англиас болон

эне компаниас импортоор орж ирэх бүх бараа таваарт хориг саад тавих ажлыг зохион байгуулах зэргээ илэрхийлсэн байна. Түүнчлэн хэрэв Британитай цаашид харилцаа сайжирч хэвийн болохгүй бол их хурлын төлөөлөгчид 1775 оны 5-р сард дахин цугларч хуралдахаар тогтжээ.

Британийн засгийн газар түрүүчийн "Тэмдэгтийн хууль", "Тауншэнд хууль" зэргийг хүчингүй болгосны адил энэ удаа "Тэвчишгүй хуулиудаа" бас хүчингүй болгохоос уур хилэн нь маш их бадарч, английн парламент Америк дахь колониудынхаа арилжаа, наймааг эрс хязгаарласан заалт бүхий шинэ дүрэм, журам боловсруулан гаргаж, колонийн бурангуй цэргийнхээ хүчин чадлыг улам зузаатгажээ.

Энэ бүх байдлаас үүдэн 1774 оны сүүлчээс эхлэн колониудын эх орончид англичуудтай зэвсгийн хүчээр үзэлцэхийн тулд хот, тосгодоод ардын цагдааг байгуулан, буу зэвсэг, галт хэрэгсэлтэй болж эхлэв. Ялангуяа Massachusetts колонийнхон Английн хааны бие төлөөлөгч генерал Гэйжийг үл хайхран, өөрсдийн арми байгуулж эхэлсэн байна.

Гэвч генерал Гэйж эх орончдыг арми байгуулж, Бостоноос баруун хойш байдаг Конкордоос буу зэвсэг, галт хэрэгсэл олж байна гэдэг мэдээг олж амагцаа 1775 оны 4-р сарын 18-нд Конкорд руу цэрэг илгээн, тэнд байгаа зэр зэвсгийн агуулахуудыг даруй эзэлж авах тушаал өгчээ. Түүнээс гадна тэр Лексингтон хотын ойролцоо байсан эх орончдын хоёр удирдагч - Самуэл Адамс, Жон Хэнкок нарыг барьж авчрахыг тушаасан байна.

Эх орончдын цагдаа нар (цэргүүд) ч Бостон дахь английн цэрэг хаашаа хөдлөхийг ажиглан хянаж, яаралтай мэдээг даруй өгч байх үүрэг бүхий элч нартай байжээ. Тэд генерал Гэйжийн төлөөлөгөөг мэдмэгцээ морьтой гурван элчийг Конкорд руу шөнөөр илгээсний хоёр нь (Поль Ривиа, Уильям Дэвис нар) замдаа англичуудад баригдан саатсан боловч гурав дахь элч Самуэл Прескотт Конкордод хүрэлцэн очиж, хотын хүмүүсийг зэвсэг барин тэмцэхэд бэлэн байх мэдээг шөнөдөө хүргэж чадсан байна.

Английн цэргүүд 1775 оны 4-р сарын 19-ны өглөө эрт Конкордод орж ирэх үед хотын төвд ардын цагдаагийн цэргүүд цугларсан байжээ. Английн цэргүүд ирмэгцээ эх орончдыг зэвсгээ даруй газар хаяхыг тушаасан боловч тэднийг байрандаа зогсож байхад нь английн цэргүүд гал нээн, 8 хүнийг алж, 10 хүнийг шархдуулжээ. Тэгээд Конкордоос 6 бээрт орших шүүхийн байшинг шатааж, эх орончдын цэргүүд (цагдаа нар) -ийн хувцас хунар, ор дээсгэр болон цэргийн бусад бүх хэрэгслийг устгажээ. Үүнийхээ дараа английн цэргүүд хотын захын гүүр дээр эх орончдын эрс шийдэмгий хэсэгтэй тулгарч, харин нэлээд буудалцсаны дараа эргэ буюу ухрахад хүрсэн байна. Тэднийг Бостон руу ухрах замд нь эх орончдын цэргүүд замын дагуух ой модон дотроос болон хад чулууны цавнаас буудан, английн 300 шахам цэргийг алж

шархдуулжээ. Ийнхүү эх орончдын цэргүүд английн цэргүүдтэй эрс шийдвэртэй тулалдаж, Конкорд, Лексингтонд ялалт байгуулсан нь английн колоничлогчдын эсрэг эх оронч америкчуудын хувьсгалт дайны эхлэл болсон байна. Эх орончдын цэргийн энэ ялалт нь эрх чөлөөний төлөө Умард Америкийн колониудын оршин суугчдын тэмцлийг эрс зоригжуулсан чухал үйл явдал болов.

Конкорд, Лексингтонд болсон тулалдааны дараа ч Америк дахь английн колониудын эх орончид Британитай асуудлыг тайван замаар зохицуулан шийдвэрлэж болно гэж найдсаар байжээ. 1775 оны 5-р сарын 10-наас Филадельфи хотноо хуралдаж эхэлсэн Эх газрын колониудын оршин суугчдын төлөөлөгчдийн хоёрдугаар их хурал ч бас иймэрхүү янзаар найдаж байв. Тэгээд ч тус их хурлаас 1775 оны зун английн Ш Георг хаанд илгээлтийг бие төлөөлөгчөөр явуулж, түүндээ америк дахь английн колониудын эдлэх ёстой эрхийг Британийн парламентийн хавчиж хязгаарлан боогдуулж буй шударга биш бодлогоос өмгөөлөн хамгаалахыг хүсэж бичсэн боловч Ш Георг хаан уг илгээлтийг уншихаас ч татгалзжээ. Нэгэнт английн хаан эх орончдын төлөөлөгчдийн их хурлын илгээлтийг хүлээн авч биелүүлэхээс татгалзсан учир их хурал эх газрын колониудын эх орончдын армийг байгуулж, түүний өрөнхий командлагчаар Жорж Вашингтоныг томиллов.

Энэ үед тодруулбал 1775 оны 6-р сарын 7-нд Америк дахь английн цэргийн командлагч генерал Гэйж Бостон хотын гаднах (ойролцоох) өндөрлөг Бункер дэжийг дайран эзлэх тушаал өгчээ. Энд ширүүн тулалдаан болж, эхний үед эх орончид английн цэргийг хоёр удаа ухралтад оруулж байсан боловч яргагүй ухрахад хүрчээ. Гэвч энд болсон тулалдаанд Англи 2,200 цэргийнхээ 1000 гаруйг алуулж ихээхэн хохирол үзсэн байна.

1775 оны 7 дугаар сард Бостон хотын ойролцоох газар эх орончдын хүчний командлагыг генерал Жорж Вашингтон гартаа авав. Хэдэн сарын турш Жорж Вашингтоны цэргүүд англичуудыг Бостон хотоос түрж гаргахыг оролдсон боловч бүтээгүй бана. Гэвч 1776 оны эхээр Эх орончдын хүчин Тикондерога боомтыг эзлэн авч, 59 их буутай болов. Эдгээрийг Дочестерийн өндөрлөгт зоож байрлуулаад Бостон хотыг гарын алган дээрээ байгаа юм шиг ил тод харж, буудаж байсан явдал тус хотыг Британийн цэргүүд орхин, Нова Скотиагийн Халифакс рүү зайлахад хүргэжээ. Ийнхүү Бостон хот Эх орончдын хүчний гарт орж ирсэн байна.

1775 оны хавраас эхлэн мөн оны эцэс хүртэл Эх орончдын өөр хүчин Бермонтоос хөдлөн Нью-Йоркийн зүүн хойд хэсэгт английн цэрэгтэй байлдааны ажиллагаа явуулж, Нью-Йоркийг эзэлснээс гадна Канадын Монтреал хотыг авчээ. Гэвч 1776 оны хавар Эх орончдын цэрэг Канадаас нутагтаа буцаж иржээ.

Америк дахь английн "Өмнөдийн колониуд"-ын Эх орончид ч 1776 оны хавраас колонилогчид болон орон нутаг дахь тэдчий хань хамсаатантай уйгагүй тэмцэл хийж байв. Английн колонилогчид өөрсдийнхөө хань хамсаатны туслацаатайгаар Умард болон Өмнөд Каролинад Эх орончдыг бут цохих оролдлого удаа дараа хийж байжээ. Харин эдгээр хоёр колонийн эх орончид Моорэ Крикт, Чарльстонд колонилогчид, тэдний хань хамсаатанд цохилт өгч, Чарльстоны дэргэдэх далайн эрэгт түр зуурын хамгаалат босгон байгуулж, Чарльстон хот руу дайрах гэсэн английн тэнгисийн байлдааны хөлөг онгоцуудыг тэндээс (уг хамгаалалтаас) буудаж байв. Үлэмжийн их хохирол үзэж байсан Британийн хөлөг онгоцууд өөр боомт руу буцахаас өөр замгүй болж байжээ.

Британийн Ш Георг хаан Америк дахь английн колониудын оршин суугчдын төлөөлөгчдийн их хурлын илгээлтийг уншихаас ч татгалзсанаар үл барам "Бослогын тухай тунхаг" гаргаж, Америк дахь колониуд Их Британийн эсрэг тэрхүү үймээн самуун дэгдээж байгаа учир тэдгээрийг даруй дарж устган, үймээн самуун дэгдээгчдийг залхаан цээрлүүлэхийг засгийн газартаа үүрэг болгосон тухай мэдэгдэж байжээ. Тэгээд ч английн засгийг газар уг үймээн самууныг дарах хөлсний цэргийг гадна, дотноос татахад хүрч, гаднаа Германы Гессен мужаас нэлээд олон тооны хүмүүс тэрхүү хөлсний цэрэгт очиж байсан байна.

Гэгчэх орончид английнх ч байна уу өөр бусад орных ч бай, тэдэнтэй тулалдах шийдвэр төгс байжээ. Эх орончдын шударга тэмцлийг зоригжуулахад тэр үед Америкт ирсэн байсан английн зохиолч Томас Пэйний бичиж 1776 оны 1-р сард бум гаруй хувь хэвлүүлсэн "Эрүүл ухаан" товхимол туйлын чухал үүрэг гүйцэтгэжээ. Зохиолч товхимолдоо америкчуудыг Их Британиас бүх талаар холдохыг уриалаад, "Америк шиг ийм том тивийг олон мянган бээрийн цаана байгаа жижигхэн арлын орон захирч байх ёсгүй", "колониудын оршин суугчдын арилжаанаймаа, үйлдээрийн эрх ашгийг хөндсөн хууль дүрэм, тогтоол шийдвэрт та нар захирагдах ёсгүй", "та нарыг дарж устгахаар цэрэг илгээж байгаа хаана та нар итгэн, үнэнчээ илэрхийлж байгаа чинь туйлын тэнэг зүйл байна", "салам тусгаарлах талаар та нарын хийж байгаа болон цаашид хийх бүхэн чинь зөв зүйтэй юм шүү" гэх зэргээр бичсэн нь америкчуудыг үнэхээр зоригжуулж, тусгаар тогтнолоо зарлахад тус дэм болж байжээ.

1776 оны хавар гэхэд Америк дахь Эх газрын английн колониудын оршин суугчдын төлөөлөгчдийн хоёрдугаар их хурал Их Британиас бүрэн тусгаар тогтнох тухай асуудлыг аач хэлэлцэв. Мөн оны 8-р сарын 7-нд Виргинийг төлөөлсөн төлөөлөгч Ричард Генри Ли энэ асуудлаар төлрөлөгчдийг үзэл бодлоо илэрхийлэх саналыг албан ёсоор тавьжээ. Түүгээр ч үл барам энэ асуудлаар тогтоолын төслийг ч төлөөлөгчидэд тавьсан байна. Лигээс оруулсан тогтоолын төсөл төлөөлөгчдийн урам зоригийг улам бадрааж, төлөөлөгчид

ихээхэн нухацтай хэлэлцсэний эцэст "Тусгаар тогтнолын тунхаглал" бэлтгэж боловсруулах 5 хүний бүрэлдэхүүнтэй хороог томилсон байна. Энэ бүрэлдэхүүнд Томас Жөфферсон, Жон Адамс, Бенжөмин Франклин, Рөжө р Шөрман, Роберт Ливингстон нар оржээ. Виргинаас ирсэн 33 настай Жөфферсон уг тунхаглалын төслийг зохион бичсэнийг хороо зарим засвар хийж, их хуралд оруулахыг зөвшөөрсөн байна.

Уг тунхаглалд хоёр чухал зорилтыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:
Нэгд,

хүмүүсийн (ард түмний) эрхийн тухай шинэ эрэлхэг үзэл санааг илэрхийлсэн. Энэ хэсэгт дурдсанаар, өнгөрсөн үед засгийн газар л ард иргэддээ ямар эрх эдлүүлэхийг тогтоох ёстой гэж өмөд хүмүүс боддог байв. Гэвч ямар ч засгийн газар хүн болж төрсний хувьд "сэлгаж авч болохгүй тийм эрх" бүх хүмүүст байх ёстой. Энэ нь амьдрах эрх чөлөө эдлэх, эз жаргалтай байх эдгээр болно. Засгийн газрын зорилт бол хүмүүсийн эдгээр эрхийг хамгаалах явдал мөн.

Аль ч засгийн газар захирагчдынхаа зөвшөөрөл гүйгээр захирч болохгүй. Өөрөөр хэлбэл ард түмнийг захирах зөвшөөрөлийг заавал тэднээс авах ёстой. Хэрэв засгийн газар ард түмний энэ эрхийг хөсөрдүүлэхийг оролдвол засгийн газрыг ард түмэн өөрчлөх буюу зайлуулах эрхтэй" гэж дурджээ.

Хоёрт,

"Тусгаар тогтнолын Тунхаглал"-аар Их Британитай бүх талын харилцааг зогсоожээ. Жөфферсон Америк дахь колониудынхаа эсрэг британийн хаан 27 "харгис хууль дүрэм" гаргасныг тоочин дурдаад, Америкийн колониуд Британиас салж, тусгаар тогтнолоо зарлаж байгаа болон энэ эрх чөлөөгөө тууштай хамгаалах тухайгаа мэдэгджээ.

Америк дахь английн колониуд нэгэнт тусгаар тогтнож байгаа учир өөрсдийгөө "Америкийн Нэгдсэн Улс" гэж нэрлэх болсон байна.

"Тусгаар тогтнолын Тунхаглал"-д Их хурлын дарга Жон Хэнкок болон бусад бүх төлөөлөгч гарин үсэг зурж, энэ тунхаглалыг 1776 оны 7-р сарын 4-нд их хурал баталжээ. Ийм ч учраас жил бүрийн 7-р сарын 4-ны өдөр бол АНУ-ын үндэсний баярын өдөр юм.

Ийнхүү одоогоос 218 жилийн тэртээ манай гаригийн баруун хагасын умард хэсэгт орчин үеийн дэлхий дахины ардчилал, цэрэг-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, боловсрол, соёлын хүчирхэг гүрэн-Америкийн Нэгдсэн Улс колоничлол, харгислалыг таягдан хаяж, тусгаар тогтнолоо тунхаглан зарласан байна.

үргэлжлэл бий.